



“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ТӨХХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН


(2024.01.01-2024.12.31)

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө, 18А-1,
Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын
үндэсний холбооны байр, II давхар



Агуулга

НЭГ. ЗАХИРГАА, САНХҮҮ	2
ХОЁР. АРИЛЖАА	12
ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	17
ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛ, БҮРТГЭЛ	18
ТАВ. ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ	21
ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ	24
ДОЛОО. ДҮГНЭЛТ	31



НЭГ. ЗАХИРГАА, САНХҮҮ

1.1. Хууль, эрх зүй:

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 233 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2023 оны 50 дугаар тэмдэглэл болон 2024 оны 5 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор “Мал, махны дуудлага худалдааны журам”-ыг боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/06 дугаар тушаалын хавсралтаар баталгаажуулав. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн А/25 дугаар тушаалын хавсралтаар “Биржийн нууц хамгаалах, нууц баримт бичигтэй ажиллах журам”, “Байгууллагын нууцын жагсаалт”, “Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг тус тус баталсныг Гүйцэтгэх захирлын 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/85 дугаар тушаалаар журмыг бүхэлд нь хүчингүйд тооцож Авлигатай тэмцэх газраас 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн зөвлөмж болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн Төрийн болон албаны нууцыг ашиглах, хадгалах, хамгаалах журам”-ыг Гүйцэтгэх захирлын 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар тушаалын хавсралтаар батлуулав. Мөн Гүйцэтгэх захирлын 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/44 дугаар тушаалаар “Гишүүнчлэлийн журам”, “Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам”, “Клиринг, төлбөр тооцооны журам”-д нэмэлт өөрчлөлт орсон. Гүйцэтгэх захирлын 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/84 дүгээр тушаалын хавсралт болох “Гишүүнчлэлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан баталсан. Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/98 дугаар тушаалын хавсралтаар “Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны түр журам”-ыг баталсан.

Мөн тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслүүдийг боловсруулж нийт 132 гэрээг байгууллаа.

Уламжлалт мал аж ахуйн салбарыг байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг даван туулах арга хэмжээг тодорхойлох, малын гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийг хоршоогоор дамжуулан зах зээлд нийлүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий хуулийн төслийг Улсын их хуралд сайдаас өргөн барихтай холбогдуулан “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах шаардлага үүссэн. Малчдыг хоршоо буюу хамтын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааны зохион байгуулалтад оруулан түүхий эд бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор тодорхой бодлого төлөвлөлтийг гарган хөнгөлөлттэй санхүүжүүлтийн эх үүсвэрийг гарган хэрэгжүүлэхээр болсон. Үүнтэй холбогдуулан биржийн арилжаанд оролцогч байнгын бус гишүүн буюу хоршоо биржийн арилжаанд зөвхөн худалдагч талаас бус худалдан авагч талаас мөн оролцох боломжийг нээх зорилгоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн тодорхой заалтуудад өөрчлөлт оруулах саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Тус хууль нь “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хэмээх нэршилтэйгээр 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан ба биржийн хуулинд өөрчлөлт ороогүй.

Монгол Улсын Засгийн газраас өрнүүлж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх таван (тав) их наядын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хоршоодод мал, мах, сүү бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах, түүхий эд бэлтгэлийн агуулах барих загвар төсөл боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем болох www.plant.mofa.gov.mn системтэй танилцаж тус системд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн захиалгын цэс оруулах боломжийн талаар санал солилцсон. Энэхүү саналын хүрээнд тариалан эрхлэгчийг биржийн арилжаанд оролцох, захиалга өгөх үйл ажиллагааг хөнгөвчлөх, гарал үүсэл баталгаажсан бараа, түүхий эдийг арилжих зорилгоор www.plant.mofa.gov.mn системд биржээр арилжих захиалга өгөх модуль нэмэлтээр хөгжүүлэх боломжийг бүрдүүлж өгөх тухай Гүйцэтгэх захирлын 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 252 дугаар албан бичгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Шүүхийн маргаан:

Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс иргэн Х.Баатараас нийт 16,798,375 төгрөг, мөн шүүх хуралдаанд оролцоход нэхэмжлэгчээс төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг тус тус гаргуулан олгохоор шийдвэрлэсэн боловч хариуцагч сайн дураар биелүүлэхгүй байх тул Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг;

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 182/ШШ2021/01154 дүгээр шийдвэрээр “МЭТУ” ХХК-аас 425,997,099 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн 2,287,935 төгрөгийг тус тус гаргуулж “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д олгохоор шийдвэрлэсний дагуу шийдвэр гүйцэтгэх албанаас 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэж “МЭТУ” ХХК-ийн банк дахь харилцах дансыг битүүмжилж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг тогтоогоод байгаа боловч өнөөдрийг хүртэл өр төлбөр барагдуулаагүй байгаа тул ажиллагааг эрчимжүүлэх албан шаардлагыг;

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд биржээс гаргасан нэхэмжлэлийн дагуу “Наранзолбоот кашмер” ХХК-иас “Зээлийн гэрээ”-ний үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн төлбөр мөн зээлийн хүү, алдангийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 26 сарын хугацаанд төлөхөөр шийдвэрлэсэн боловч хариуцагч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байх тул Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлж өгөх хүсэлтийг тус тус хүргүүлээд байна.

1.2. Санхүү, аж ахуй:

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийт 14 нэр төрлийн мэдээлэл мэдээлэхээс худалдан авах ажиллагааны 46 шийдвэр буюу 1,015,171,650 төгрөгийн, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 3,845,649,950 төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй байснаас 174,365,550 төгрөгийн гүйцэтгэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 6,050,441,003.08 төгрөгийн 87 ажил гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ

9,095,508,144.07 төгрөгийн 208 ажил гүйлгээний гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь тогтмол оруулж, 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар ажил гүйлгээг хугацаанд нь тогтмол мэдээллэн ажиллалаа.

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт борлуулалтын орлогыг 3 орчим хувиар давуулан биелүүлээд байна. Нийт зардлыг төсөвт тусгагдсан хуваарийн дагуу санхүүжүүлэн 90 орчим хувийн гүйцэтгэлтэй буюу зардлын хэтрэлтгүй, хэмнэлттэй ажиллаж байна.

1.3. Дотоод хяналт, мониторинг:

Хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн мөрдүүлж, журмын хэрэгжилтийг хангахад хяналт тавих зорилгоор дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу хяналт тавин ажиллалаа.

Клирингийн үйл ажиллагаа, хэлцэл, төлбөр тооцоо зэрэг заалтуудын хэрэгжилтэд анхдагч болон баталгаат дэнчин, клирингийн эрхтэй гишүүний барьцаа, Худалдах худалдан авах гэрээ, клиринг төлбөр тооцооны тайлан, банкаар хийгдсэн гүйлгээний журнал зэрэг шаардагдах материалуудад хяналт хийсэн.

Хөдөө аж ахуйн биржийн тухай хуульд заасны дагуу биржийн арилжаанд оролцогч байнгын болон байнгын бус гишүүдэд тавигдах шаардлага, гишүүнчлэлийн төрөл, биржид гишүүнээр элсүүлэх, сургах, эрхийг түтгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагаанд хяналт тавих, гишүүнчлэлийн журмын хэрэгжилтийг хангаж буй эсэхэд хяналт тавих зорилгоор холбогдох материалуудад хяналт тавин ажиллалаа.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийг биржээр арилжсаныг нотлох тодорхойлолт олгохтой холбоотой тодорхойлолтын хүсэлт хүлээн авах, тодорхойлолтыг олгох, дахин олгох, хүчингүй болгох, тодорхойлолтын маягт захиалж хэвлүүлэх, бүртгэх, хадгалах, архивт хүлээлгэн өгөхтэй холбоотой журмын хэрэгжилтийг хангаж буй эсэхэд хяналт, мониторинг хийв. Үүнд: Биржийн арилжааг бодитой хийх зорилгоор брокерууд дундын зуучлалын үүргээ гүйцэтгэхдээ гадаадын худалдан авагчдыг биржийн арилжааны харилцагчаар татан оролцуулахаар шийдвэрлэсэн. Ингэснээр брокерын компаниуд татварын өрөнд орох, гадны компаниуд өөрийн нэрээр биржийн арилжаанд орохгүй байх эрсдэлүүдээс хамгаалсан оновчтой шийдвэр болсон. Үүнтэй холбогдуулан биржийн тодорхойлолт олголтод “Худалдан авагч талын харилцагч, экспортлогч буюу худалдагч талын харилцагч”-дыг тодруулан шинэ загварын тодорхойлолтыг бэлтгэн 2024 оны 5 дугаар сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/31 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх, Шилэн дансны хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, сар, улирлаар хяналт хийж, Гүйцэтгэх захиралд танилцуулах зорилгоор 2024 оны 1, 2 дугаар улирлын “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-нд тус хяналт хийлээ.

Хяналтын журмыг үндэслэн шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хэлтэс тус бүрээр нь зөвлөмж хүргүүлсэн бөгөөд Нийцлийн хяналт, Гүйцэтгэлийн хяналтаар хэлтсүүд журмын хэрэгжилтэд төлөвлөгөө гарган биелэлтийг ханган ажиллаж байна.

1.4. Хүний нөөц, сургалт:

Олон улсын жишигт бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааг амжилттай авч явах, хөгжүүлэх чухал хүчин зүйлийн нэг бол чадварлаг баг, боловсон хүчин байдаг. Биржийн үйл ажиллагаа нь түүний гишүүд болон харилцагчдад найдвартай үйлчилгээ үзүүлэх чадварлаг хүний нөөц дээр тулгуурлах бөгөөд мэдлэг, туршлагатай хүний нөөцийг эрэлхийлж, тасралтгүй хангагдаж байх нь чухал юм. Биржийн зүгээс энэ салбарт ажиллаж туршлага хуримтлуулсан чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, шинээр чадвар, туршлагатай ажилтан авч ажиллуулахаар зорин хүний нөөцийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байна.

Компанийн 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Төрийн худалдан авах ажиллагааны суурь мэдлэг, эрх олгох, мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс эхлүүлэн 16 ажилтныг, 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр “Худалдан авах ажиллагааны хөтөч” сургалтын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж компанийн 18 ажилтныг тус тус хамрууллаа.

Авлигатай тэмцэх газраас 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдөр цахимаар зохион байгуулсан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах” сургалтад компанийн 8 ажилтан оролцсон.

Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан Төрийн жинхэнэ алба хаагчийн томилгоонд гарч буй нийтлэг зөрчил, түүнийг багасгах заавар, зөвлөмж /7:4:10 арга зүйн семинар/ цахим сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсээс 2 ажилтан хамрагдан суралцлаа.

2024 оны 5 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Энэтхэг Улсад “Мэдээллийн технологийн цахим халдлага, аюулгүй байдал”-ын чиглэлээр 15 хоногийн түргэвчилсэн сургалтад 1 ажилтан хамрагдаж амжилттай төгссөн.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого" хөтөлбөрийн "Аж үйдвэржилтийн сэргэлт, "Хот, хөдөөгийн сэргэлт", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 419 дүгээр тогтоолыг үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор манлайлал үзүүлж, санаачилга гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт шилжүүлэх ажлын хүрээнд "Хөдөө аж ахуйн бирж" компанийг шилжүүлэхэд шилжин ажиллах боломжтой эсэх талаарх судалгаа, санал асуулгыг авч тус аймагт ажиллах, амьдрах боломж ба шинээр ашиглалтанд орж буй орон сууцны талаарх танилцуулга, хурал зохион байгууллаа.

1.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Компанийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах боломжит судалгааг хийх, хамтын ажиллагааг эхлүүлэн тогтвортой үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин дараах байдлаар ажиллалаа.

БНХАУ-ын Гуанжөү хотод жил бүр зохион байгуулагддаг “Canton fair 2024” 135 дахь удаагийн арга хэмжээнд оролцох, гадаад худалдан авагчдыг дотоодын үйлдвэрүүдтэй холбох, арилжаанд татан оруулах боломжийг судлах, ложистик,

агуулахын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай холбоо тогтоох, туршлага солилцох, сүүлийн үеийн ололт, сайн жишээг нутагшуулах зорилгоор “Хөдөө аж ахуйн бирж”-ийн төлөөлөгчид БНХАУ-д албан томилолтоор ажиллав. Энэ хүрээнд худалдан авагч, үйлдвэрлэгч байгууллагуудтай холбоо тогтоосон бөгөөд цаашид хамтран ажиллах боломжийг судалж байна.

Бүгд Найрамдах Беларусь Улсад зохион байгуулагдсан хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн “Белагро-2024 үзэсгэлэн”-д 2024 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс 12-ны өдрүүдэд оролцсон. Мөн тус улсын товарын бирж (Belarusian universal commodity exchange-BUCE)-тэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж талууд биржээр бараа, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан арилжаалах талаар хэлэлцэн эхний ээлжинд Монголын талаас ноолуур, зэс, төмрийн хүдэр, Беларусийн талаас хуурай сүү, мод, модон бүтээгдэхүүн /палк, рек, бэлдэц/, сайн чанарын элсэн чихрийг арилжих талаар судлахаар тохиролцсон.

Сингапур Улсын “SGX” биржтэй холбоо тогтоон хамтран ажиллахаар удаа дараа албан хүсэлт, цахим шуудан илгээсний дүнд Түүхий эдийн арилжааны хэлтсийн дарга William Chin-тэй холбогдон 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс 07-ны өдрүүдэд “Хөдөө аж ахуйн бирж”-ийн төлөөлөл Сингапур улсад ажиллав. Сингапурт байршилтай үнэт цаас, клиринг төлбөр тооцооны цогц үйл ажиллагаа явуулдаг тус биржийн төв байранд 5 дугаар сарын 3-ны өдөр уулзалт хийн, 2 тал тус тусын биржийн үйл ажиллагааг танилцуулж санал солилцсон. Сингапурын хөрөнгийн биржийн SGX DT (Derivatives Trading)-тэй харилцаагаа гүнзгийрүүлэн дараагийн түвшинд хамтын ажиллагааг эхлүүлснээр дотоодын түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг гадны худалдан авагчид хүргэхэд илүү хялбаршуулах боломжтой болно. Үүний хүрээнд эхний удаад харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар ажиллаж байна.

Бүгд Найрамдах Узбекистан улсын “UZEX” биржтэй байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа дараагийн түвшинд гаргахаар ажиллаж байна. Үүний дагуу хоёр бирж хоорондоо улиралд нэг удаа тогтмол цахим уулзалт хийхээр тохирсон. Монгол улсаас БНУУ руу хийж буй махны экспортыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэгчдийг гадаад худалдан авагчтай холбохоор зорьж байна. Үүний дагуу хамтран ажиллах төлөвлөгөө гарган, мах экспортлогч компаниудыг гадны худалдан авагчтай холбох, дотоодын брокеруудыг чадавхжуулах, тус биржийн брокеруудыг Монгол улсын худалдан авагч талтай холбох зэрэг шат дараатай ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Дэлхийн банкны Өмнөд-Өмнөд хамтын ажиллагааны санаачилгын хүрээнд Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн шугамаар сайн туршлага хуваалцахаар Монгол Улсад айлчилж буй Этиоп Улсын “Нам дор бүс нутагт мал аж ахуй эрхлэгчдийн дасан зохицох чадавхыг бэхжүүлэх” төслийн ахлах эдийн засагч Исаяас Нигату тэргүүтэй төлөөлөгчдөд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг танилцуулж, малын гаралий түүхий эд, бүтээгдэхүүнийг арилжаанд оролцуулж зах зээлд нийлүүлэх талаар санал солилцсон.

Биржийн гадаад харилцааг өргөтгөх, ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч биржтэй холбогдох, харилцаа тогтоох чиглэлээр ажилласны дүнд Хонгконгийн биржийн Гадаад харилцааны хэлтсийн дарга Силвиа Чентэй цахим уулзалт хийх боломж олдсон. Тус цахим уулзалтаар тухайн компанийн үйл ажиллагаатай биечлэн

танилцахыг урьсантай холбогдуулан 2024 оны 12 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Хонгконгийн биржтэй уулзалт хийсэн. Уулзалтаар Монголын хөдөө аж ахуйн биржийн үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн гүйцэтгэж буй үйл ажиллагааны товч танилцуулга болон өөрийн орны онцлогт суурилан хөгжиж буй компанийн бизнесийн онцлогийн талаар танилцуулга хийж харилцан санал солилцсон. Цаашид Монголын хөдөө аж ахуйн биржээр үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих, олон улсын жишигт нийцсэн арилжаа, төлбөр тооцооны цогц систем бүхий технологийн шинэчлэл хийх бэлтгэл ажилтай холбогдуулан тус бирж дээр дадлагажин ажиллах боломжийг эрэлхийлэн дэмжин ажиллахаа илэрхийлсэн.

Биржийн гадаад харилцааг өргөтгөх, ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч биржтэй холбогдох, харилцаа тогтоох чиглэлээр БНХАУ-ын Шанхайн фьючерсийн биржтэй удаа дараа холбоо барьсаны дүнд 2024 оны 12 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Монголын хөдөө аж ахуйн биржийн төлөөлөгчид тус бирж дээр хүрэлцэн очиж уулзалт хийсэн. Уулзалтаар Монголын хөдөө аж ахуйн биржийн үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн гүйцэтгэж буй үйл ажиллагааны товч танилцуулга болон өөрийн орны онцлогт суурилан хөгжиж буй компанийн бизнесийн онцлогийн талаар танилцуулга хийж харилцан санал солилцсон. Цаашид Монголын хөдөө аж ахуйн биржээр үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих, олон улсын жишигт нийцсэн арилжаа, төлбөр тооцооны цогц систем бүхий технологийн шинэчлэл хийх бэлтгэл ажилтай холбогдуулан спот гэрээний арилжаанаас фьючерсийн гэрээний арилжааг хийх шилжилтийн үеийг даван туулахад зөвлөгөө өгч, дэмжин ажиллахаа илэрхийлсэн.

Хөдөө аж ахуйн биржээс үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих, олон улсын жишигт нийцсэн арилжаа, төлбөр тооцооны цогц систем бүхий технологийн шинэчлэл хийх бэлтгэл ажлын хүрээнд арилжаа, клиринг, төлбөр тооцооны системийн чиглэлээр туршлага бүхий Малайзын хөрөнгийн биржтэй удаа дараа харилцаа холбоо тогтоохоор холбогдсоны дүнд 2024 оны 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Монголын хөдөө аж ахуйн биржийн төлөөлөгчид тус биржид хүрэлцэн очиж Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга Эмилия Ти Хонгтой уулзалт хийсэн. Уулзалтаар Монголын хөдөө аж ахуйн биржийн үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн гүйцэтгэж буй үйл ажиллагааны товч танилцуулга болон өөрийн орны онцлогт суурилан хөгжиж буй компанийн бизнесийн онцлогийн талаар танилцуулга хийж харилцан санал солилцсон. Малайзын хөрөнгийн биржийн Тогтвортой хөгжлийн хэлтэс нь сургалт хөтөлбөрийн асуудлыг мөн хариуцдаг тул Монголын хөдөө аж ахуйн биржийн ажилтаныг тус бирж дээр дадлагажин ажиллах боломжийг эрэлхийлэн дэмжин ажиллахаа илэрхийлсэн.

1.6. Архив, албан хэрэг хөтлөлт:

Тайлант хугацаанд компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 117, хүний нөөцтэй холбоотой тушаал 131, мөн 385 албан бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, заавар, журмын дагуу албажуулж, гадны байгууллагаас ирүүлсэн 228 бичиг, 13 өргөдөл хүлээн авч бүртгэн, удирдлагын цохолтоор хэлтсүүдэд хуваарилан хариуг гаргуулан, бүртгэл хяналтын карт хөтөлж ажиллалаа.

2023 оны баримт материалуудыг архивлах ажлын хүрээнд Захиргаа санхүүгийн хэлтэс 54, Арилжааны хэлтэс 13, Стратеги төлөвлөлтийн хэлтэс 2, Клиринг төлбөр тооцооны хэлтэс 53, Гишүүнчлэл бүртгэлийн хэлтэс 6, Цахим хөгжүүлэлтийн хэлтэс 3 боть баримтуудыг тус тус архивт хүлээн аваад байна.

1.7. Маркетинг:

Компанийн 2024 оны маркетингийн төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, цахим хуудсыг хөгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын албан ёсны цахим хуудаст дараах байдлаар мэдээллийг байршуулж байна. Үүнд:

- Даваа гарагт- Долоо хоногийн арилжааны тойм мэдээ
- Мягмар гарагт- Биржийн үйл ажиллагаатай холбоотой танин мэдэхүйн мэдээ
- Лхагва гарагт- Олон улсын мэдээ, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын сонин хачин
- Пүрэв гарагт- Бусад мэдээлэл (салбарын хүрээнд)
- Баасан гарагт- Цаг үеийн мэдээ, онцлох мэдээ байдлаар календарчилан бэлтгэн нийтэлж байна.

Эдгээр календарчилсан мэдээ, мэдээллүүдийг түгээхээс гадна тухайн өдрийн цаг үеийн шинжтэй мэдээ, арилжааны мэдээ, онцлох үйл явдал, салбарын мэдээ, инфографик зэрэг мэдээ мэдээллүүдийг цаг алдалгүй түгээж ажилласан.

Мөн компанийн долоо хоног тутмын арилжааны мэдээг Bloomberg TV-ийн мэдээний буланд байршуулж олон нийтэд түгээн ажиллалаа.


2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 1.5 сая болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 909 хувиар өссөн байна. Мөн цахим хуудасны дагагчдын тоо 2600 гаруй хүнээр нэмэгдсэн нь мөн үетэй харьцуулбал 154 хувиар өссөн. Энэхүү үзүүлэлт нь цэвэр органик өсөлт бөгөөд нэмэлт төлбөртэй мэдээ байршуулалгүйгээр нэмж чадсан байна.

Мөн мэдээ, мэдээллийг зурган контентоор хүргэх зорилгоор инстаграм платформд шинээр профайл үүсгэн ажиллаж байгаа бөгөөд твиттер профайлыг хөгжүүлэхээр мөн шинээр үүсгэсэн. Одоогийн байдлаар мэдээ, мэдээллийг энэ улирлаас эхлэн компанийн албан ёсны цахим сүлжээний 4 сувгаар /фейсбүүк, твиттер, вебсайт, инстаграм/ түгээн хөгжүүлж байна.


Цахим хуудасны статистик мэдээ



Цахим хуудасны анализ



Өмнөх оны мөн үетэй харьцуулбал



“Мал, махны зарын платформ” хэрхэн ашиглах заавар танилцуулгыг бэлтгэн олон нийтийн сүлжээгээр дамжуулан 21 аймаг, 330 сумдын группүүдэд түгээж ажиллалаа.

Ноолуур, Ноос, Тэмээний ноос, Арьс шир зэрэг түүхий эдийг бэлтгэх цахим гарын авлагын эх бэлтгэлийг хийж гүйцэтгэн QR код үүсгэн цахимжуулсан.



2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийт 308 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж ажилласан байна. Үүнээс 175 мэдээний постерийн эхийг бэлтгэсэн ба 14 видео контент хийж гүйцэтгэн ажиллалаа.

Гадаадын зах зээлийн хэрэглэгчдэд компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор англи хэл дээр хэвлэмэл болон цахим танилцуулга хийж гүйцэтгэсэн. Мөн олон нийтэд компанийн үндсэн хэвлэмэл танилцуулгыг агуулга, мэдээллийг шинэчлэн утас, таблет, компьютерээсээ шууд үзэж танилцах боломжтойгоор цахим хэлбэрээр хийж гүйцэтгэсэн.



“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд малчдад хоршооны үйл ажиллагаа, давуу тал болон хэрхэн биржийн арилжаанд оролцох хэвлэмэл танилцуулгын эх бэлтгэлийн ажлыг хийж гүйцэтгэн хэвлэлтэд өгч 21 аймаг 330 суманд танилцуулах зорилгоор тараалтын ажлыг ЖДҮ-тэй хамтран хийж гүйцэтгэсэн.

Та дотор ОБ ивд уншуулам түүхий эдийн засагн шатны төрлөө, чанар, стандартын дагуу байлгах гарын авлагатай танилцуулга уу

ХААБ
Хөдөө Аж Ахуйн Бирж

БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ

- www.mce.mn
- 70128779, 70148779
- Хөдөө Аж Ахуйн Бирж ТӨХХК
- Энхтайвны орш чөлөө, 15А-1, Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоолгчдын Үндэсний Холбооны байр, 2 давхар

ХААБ | ТАНИЛЦУУЛГА
ХОРШОО

Улаанбуудайн арилжааг зохион байгуулахаар бэлтгэл ажлын хүрээнд шаардлагтай хэвлэл, эх бэлтгэл, видео шторк, баннер, стенд, танилцуулга, постер болон хэвлэл мэдээллээр олон нийтэд түгээх ажлыг хийж гүйцэтгэсэн. Олон нийт дунд хамгийн өндөр хандалттай томоохон сайтууд болох gogo.mn, medee.mn, ikon.mn, ubn.mn, ivoice.mn, ergelt.mn, isee.mn, focus.mn, dnn.mn, zogii.mn зэрэг 10 гаруй сайтуудаар улаанбуудайн арилжааны талаарх мэдээ, мэдээллийг түгээн ажилласан байна.



УЛААНБУУДАЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Бид хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гарал үүсэл, чанар, стандарт хангасан үр тариа, улаанбуудайг зах зээлийн бодит үнээр арилжих нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Дуудлага худалдаа нь "Англи дуудлага худалдаа" буюу нэг худалдагч, олон худалдан авагч гэсэн зарчмаар явагдана. Худалдагч тал зарах барааны хэмжээ, төрөл ангилал, доод үнийн захиалга өгөх бөгөөд үнэ хаялцах зарчмаар буюу хамгийн өндөр үнээр захиалга биелнэ. Үнэ, хугацаа гэсэн дарааллыг мөрдөж, төлбөр тооцоог захиалгад өгсөн үнийн саналаар гүйцэтгэнэ.

ДУУДЛАГА ХУДАЛДААНД БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛ

- 1 cloud.mn/register аарх холбоос руу орж **ОВОГ НЭР, РЕГИСТРИЙН ДУГААР, ХОЛБОГДОХ УТАСНЫ ДУГААР, И-МЕЙЛ** хаягаа зөв бөгөөд нэвтрэх нууц үгээ зохионо.
- 2 Өөрийн мэдээллийг бөглөсний дараа үйлчилгээний нөхцөлтэй танилцан **"Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрөх"** гэснийг чаталж зөвшөөрч байна товчлуур дээр дарна.
- 3 Таны бүртгэлтэй мейл хаяг руу баталгаажуулах холбоос илгээсэн байх ба холбоосоор орж баталгаажуулалт хийнэ.
- 4 Энд **дарж нэвтрэнэ үү** хэсгийг сонгон өөрийн бүртгүүлсэн мейл хаяг болон нууц үгээ оруулаад нэвтрэнэ.

ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРЛОЦХОХ ЗААВАР

ХУДАЛДАГЧ ТАЛ

Компаний мэдээлэл, зарах бараа, түүхий эдийн мэдээлэл, итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, чанар, ангилал, зэрэглэл тогтоолгосон бичиг, гарал үүслийн гэрчилгээ, зарах барааны байршил, үнэ, тоо хэмжээний мэдээллийг auction@mcc.mn хаягаар бүртгүүлнэ.

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛ

- 1 cloud.mn дуудлага худалдааны системд өөрийн бүртгэлээр нэвтрэх каталогаас өөрийн оролцох дуудлага худалдааг сонгон **ОРЛОЦХОХ** товчийг дарна.
- 2 Бараа, түүхий эдийн далгарангүй мэдээлэл
- 3 Таны оролцож буй дуудлага худалдааны хувийн дугаар
- 4 Хамгийн сүүлийн санал болгосон үнийн санал
- 5 Үргэлжлэх хугацаа
- 6 Үнэ оруулах хэсэг
- 7 Санал илгээх




ХОЁР. АРИЛЖАА

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 178 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 936 хэлцлээр 996.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 5,862.5 тонн ямааны ноолуур, 3,400.6 тонн ямааны завод ноос, 6,392.0 тонн хонины ноос, 1,020.6 тонн тэмээний ноос, 26.5 тонн завод ноос, 1,100.0 тн хүнсний улаанбуудай, 4,422.0 тонн тосны ургамал /рапс/ арилжсан.


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад арилжаатай өдрийн тоо багасаж, арилжааны нийт үнийн дүн 17.2 хувиар өссөн байна. Нийт үнийн дүн өсөлттэй байгаа шалтгаан нь ноолуурын үнийн дүнгийн зөв тооцоолол болон зудын нөхцөл байдлаас шалтгаалан ямааны завод ноос их хэмжээгээр арилжаанд орсонтой холбоотой.

2024 онд арилжсан бараа, түүхий эдийн хэмжээ, үнийн дүн



Энэ оны хамгийн өндөр дүнтэй арилжаа 7 дугаар сарын 02-ны өдөр 32.9 тэрбум төгрөг байсан бол, 3 дугаар сарын 27-ны өдөр хамгийн бага буюу 39.1 сая төгрөгийн дүнтэй байлаа.

Бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтээс хамааралтайгаар I болон IV улиралд арилжааны тоо багасаж, харин II болон III улиралд арилжаа идэвхждэг. Хөдөө аж ахуйн бирж нь 2013 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар нийт 8 их наяд 195 тэрбум төгрөгийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулаад байна.



2024 онд арилжаанд оролцсон 5 брокерын компани, 99 аж ахуйн нэгжид 953 ширхэг бараа, түүхий эдийн экспортын тодорхойлолт олгосон байна.

Хүнсний улаанбуудайн арилжаа

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/42 дугаар тушаалаар “Улсын нөөцөд худалдан авах болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлэх хүнсний улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжих бэлтгэл ажлыг хангах, арилжааг зохион байгуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр улсын нөөцөд худалдан авах болон үйлдвэрүүдэд нийлүүлэх улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр арилжих нээлтийн туршилтын арилжааг зохион байгуулсан. “Улаанбуудайн туршилтын арилжаа”-аар “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн Хөтөл салбарын элеваторт хадгалагдаж байсан 2 дугаар зэрэглэлийн 100 тонн улаанбуудай, 4 дүгээр зэрэглэлийн 1000 тонн улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-аар дамжуулан арилжааны системд захиалга өгч арилжсан бол 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 2024 оны ургац хураалтын 20 тонн хүнсний улаанбуудай, 2023 оны ургац хураалтын 530 тонн тэжээлийн улаанбуудай, 2024 оны ургац хураалтын 228 тонн тэжээлийн улаанбуудайг дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжсан.

Хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны мэдээ

№	Буудайн төрөл	Авах харилцагчийн нэр	Хэмжээ, тонн	Нийт үнэ
1	2-р зэргийн хүнсний улаанбуудай	“Улаанбаатар гурил” ХХК	20	22,100,000
2	Тэжээлийн буудай	“Хөвсгөл алтандуулга” ХК	268	179,560,000
3	Тэжээлийн буудай	“Түмэн шувуут” ХК	228	151,620,000
4	Тэжээлийн буудай	“Майнд Теч” ХХК	108	72,360,000
5	Тэжээлийн буудай	“Түмэн шувуут” ХК	154	102,410,000
	Нийт		778	528,050,000

Үрийн улаанбуудайн арилжаа

2025 оны хаврын тариалалтад шаардагдах үрийн улаанбуудайн дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжиж байгаа бөгөөд тус дуудлага худалдааг 7 хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол зохион байгуулж байна. Дуудлага худалдаагаар дараах сортын үрийн улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр арилжаад байна. Үүнд:

- Дархан 144
- Бурятская остистия
- Алтайская 325
- Алтайская 70
- Юнион
- Гонец
- Вандуй /мадона/

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 26-ны өдрийн хугацаанд дээрх 7 сортын 1066 тонн үрийн улаанбуудайг арилжсан ба дуудлага худалдааны арилжааны үнийн дүн 1.7 тэрбум төгрөг байна.

Үрийн улаанбуудайн дуудлага худалдааны мэдээ

№	Буудайн төрөл	Хэмжээ, тонн	Үнийн дүг
1	Дархан 144	211	360,895,000.00
2	Юнион	75	112,875,000.00
3	Гонец	285	431,925,000.00
4	Бурятская остистия	300	518,255,000.00
5	Алтайская-325	60	75,300,000.00
6	Алтайская -70	133	201,315,000.00
7	Вандуй мадона	2	5,570,000.00
	Нийт	1066	1,706,135,000.00

Үрийн болон хүнсний улаанбуудайн арилжааг дуудлага худалдааны системээр 6 удаа зохион байгуулж, нийт 37 аж ахуйн нэгж, иргэн оролцсон байна.

Мал, махны арилжаа

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 233 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2023 оны 50 дугаар тэмдэглэл болон 2024 оны 5 дугаар тэмдэглэлийг тус тус хэрэгжүүлэхтэй холбогдуулан мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд нийлүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан Үүнд:

- Малчид, мал бүхий этгээд, хоршоод, фермерүүд, үйлдвэрүүд, зах, бөөний худалдааны төв, ресторан зэрэг Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчид нь орон зай, цаг хугацаанд баригдахгүйгээр жилийн турш хаанаас ч мал, махыг авах болон зарах захиалга байршуулах боломжтой нээлттэй, хялбар худалдааны платформ болох www.ariljaa.mce.mn сайтыг хөгжүүлэн нэвтрүүлсэн.

- Улаанбаатар хотын Эмээлт төвд байрлах Хөдөө аж ахуйн биржийн “Ложистикийн төв”-д 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Малын төвлөрсөн арилжаа”-г явуулсан. Малчин үйлдвэрийг холбосон дундын зуучлалгүй тус арилжаанд 629 толгой бог малын спот гэрээ, 600 бог малын форвард гэрээний арилжааг тус тус хийсэн. Тус арилжаанд “Мах импэкс” ХК, “Агро нэгтгэл” трейд, “Кенбо” ХХК, “Глобал органик трейд” ХХК, “Дэлгэрэх” ХХК тэргүүтэй мах боловсруулах үйлдвэрүүд худалдан авагчаар оролцож малчны гараас шууд худалдан авалт хийсэн.
- Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран Завхан, Увс аймгуудад цөм сүргийн нэгжийн малаас ялган төвлөрүүлсэн хэрэгцээний 785 бог малыг биржээр арилжсан. Увс аймгийн арилжаанд "Увс Мах Маркет" ХХК, "Гранд Мийт" ХХК, Иргэн Ц.Нацагдорж нар оролцож үнэ хаялцан 287 хонь, 41 ямааны багцыг "Гранд мийт" ХХК, 107 хурганы багцыг Ц.Нацагдорж нар худалдан авсан бол Завхан аймагт 1 аж ахуйн нэгж, 3 иргэн оролцож, 350 толгой бог малыг амжилттай арилжлаа.
- Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн Төв, Архангай, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Хөвсгөл аймгуудын сумдын малчдын гар дээр байгаа мал, махыг мах бэлтгэлийн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч худалдан авагч аж ахуйн нэгжүүдийг тээврийн хэрэгслийнх нь хамтаар дагуулан очиж зарах барааны биет үзлэгийг хийсний дараагаар дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжааг зохион байгуулсан. Ингэснээр малчдад нөөцөлсөн махаа хадгалалтын нөхцөлөөс шалтгаалан муутгах эрсдэлээс сэргийлэх, мөн тээврийн зардал төлөхгүйгээр орон нутгаасаа мал, махаа худалдан борлуулах боломжийг олгосон бол үйлдвэр болон бусад худалдан авагчдад нэг дороос бөөн худалдан авалт хийх, хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, эргэлтийн санхүүжилтийн эх үүсвэртэй болох боломжийг бий болгосон.
- Мал, махны арилжааг эрчимжүүлэх зорилгоор биржийн гишүүн хоршоод болон мах бэлтгэх, боловсруулах чиглэлийн 177 үйлдвэрээс худалдах, худалдан авах захиалгыг утсаар, цахимаар, www.ariljaa.mce.mn сайтаар тус тус авч зуучлалын үйл ажиллагааг явуулсан. Мөн Чингэлтэй дүүрэг Дэнжийн 1000-д байрлах ХААН банкны “Нарлаг дэнж” салбарын хамт олонтой хамтран мах бэлтгэн нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд Мах бэлтгэлийн эргэлтийн хөрөнгийн зээл болон биржийн үйл ажиллагааг танилцуулан, 22 мах бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэн, ХААН банкны эдийн засагчаар зээлээ судлуулан, зээлд хамрагдахаар биржид хүсэлтийг хүлээн авч, бүртгэлжүүлж холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 558 хэлцлээр 1,892.3 тн мах, 34,744 толгой амьд хонины 20.3 тэрбум төгрөгийн арилжааг зохион байгуулсан. Үүнд, 602.7 тн хонины мах, 664.5 тн үхрийн мах, 393 тн ямааны мах, 201.1 тн адууны мах, 31.0 тн тэмээний махны арилжааг зохион байгуулаад байна.

АРИЛЖАА

Малчид, мал бүхий этгээд, хоршоод, фермерүүд, үйлдвэрүүд, зах, бөөний худалдааны төв, ресторан зэрэг Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчид нь орон зай, цаг хугацаанд баригдахгүйгээр жилийн турш хаанаас ч мал, махыг авах болон зарах захиалга байршуулах боломжтой нээлттэй, хялбар худалдааны платформ болох WWW.ARILJAA.MCE.MN сайтыг хөгжүүлэн нэвтрүүлсэн.

558 хэлцлээр 1,892 тн мах, 34,744 толгой амьд хонины 20.3 тэрбум төгрөгийн арилжааг зохион байгуулсан


399
Малчин

22
Аж ахуй нэгж

20.3 ТЭРБУМ
Арилжааны дүн

АРИЛЖААНЫ НИЙТ ҮНИЙН ДҮН

Хонины мах 5.2 тэрбум ₮ Адууны мах 2.1 тэрбум ₮
 Үхрийн мах 6.5 тэрбум ₮ Ямааны мах 2.5 тэрбум ₮
 Амьд мал 3.8 тэрбум ₮



АРИЛЖААНД ОРСОН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ

Мал, махны арилжаанд үхрийн мах хамгийн их, тэмээний мах хамгийн бага орсон байна.

Хонины мах 31.8% Үхрийн мах 35.1%
 Ямааны мах 20.8% Адууны мах 10.6%
 Тэмээний мах 1.6%



ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 936 хэлцлийн худалдах, худалдан авах гэрээг баталгаажуулж, 996.8 тэрбум төгрөгийн спот гэрээний төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна.

Биржийн төлбөр тооцооны дүн, /сая төгрөг/

	2020	2021	2022	2023	2024
Дебит	488,738.43	794,561.72	1,110,401.27	968,432.25	996,870.64
Кредит	488,738.43	794,561.72	1,110,401.27	968,432.25	996,870.64

Мөн тус хугацаанд нийт 85.7 тэрбум төгрөгийн дэнчингийн гүйлгээ хийгдэж, тайлант хугацаанд клиринг, төлбөр тооцооны аливаа эрсдэл гараагүй, төлбөр тооцоо хугацаандаа хийгдсэн болно.

Дэнчин, барьцаа, худалдах, худалдан авах гэрээтэй холбогдох бичиг баримтыг бүртгэлжүүлэх, хянах, хадгалах, гүйлгээг хураангуйлах, өдрийн эцэст тайлан гаргах, нэгтгэх зэрэг клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг өдөр тутам зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд харилцах данснуудын журналыг сар, улирал, жилээр нэгтгэн гаргаж байна.

Улсын нөөцөд худалдан авах болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлэх хүнсний улаанбуудай болон 2025 оны хаврын тариалалтад шаардагдах үрийн улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжиж эхэлсэнтэй холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/98 дугаар тушаалаар батлагдсан “Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны түр журам”-д зааснаар дэнчин болох худалдан авалтын үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг биржийн Хаан банкин дахь клирингийн дансанд байршуулан дуудлага худалдааны ялагчийн хүсэлтийг үндэслэн “Худалдах, худалдан авах гэрээ”-ний төлбөрийн үүргийг тус дэнчингээр хангуулах боломжоор ханган ажиллаж байна.

Мөн 2023 оны “Худалдах, худалдан авах гэрээ”, төлбөр тооцооны болон дэнчингийн дансны хуулга, төлбөрийн нэхэмжлэх, дэнчингийн хүсэлт, гүйлгээний баримт болох нийт 30 боть бэлтгэн, архивд хүлээлгэн өгөв.


ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛ, БҮРТГЭЛ

4.1. Биржээр арилжаалах бараа, түүхий эдийн хяналт, бүртгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйлдвэрийн дэргэдэх 25 агуулах, орон нутгийн 116 агуулах биржтэй “Агуулахын итгэмжлэлийн гэрээ” байгуулж, хамтран ажиллаж байна.

Агуулахын удирдлагын системд бүртгүүлсэн 7 итгэмжлэгдсэн агуулахын бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээнд 10 удаа биет болон цахимаар хяналт хийж бараа, түүхий эдийн харагдах байдлыг фото зургаар баримтжуулан “Агуулахын нөөцийн мэдээлэл” бүртгэх маягтад холбогдох агуулахын ажилтнаар гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан.

Агуулахын удирдлагын системд бүртгүүлсэн бараа, түүхий эдийн хэмжээ, тн



2024 онд дараах харилцагчидтай итгэмжлэлийн болон гишүүнчлэлийн гэрээ байгуулан ажиллалаа. Үйлдвэрийн дэргэдэх нийт 25 итгэмжлэгдсэн агуулах тогтмол арилжаанд оролцож байна.

- “Жин корона”, “Ви Си”, “Инэл кашемир” ХХК-ийн биржийн итгэмжлэгдсэн агуулахуудад хадгалагдаж буй бараа, түүхий эдэд биет хяналтыг хийж, харилцан мэдээлэл солилцон, бараа, түүхий эдийг биржийн барааны тодорхойлолтын дагуу кодлох, “Агуулах удирдлагын систем”-д бүртгэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, “Агуулахын итгэмжлэлийн гэрээ”-г шинэчлэн байгуулсан.
- Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн Хөтөл, Сэлэнгэ, Дархан салбарын үр тарианы силос, элеваторуудыг биржийн итгэмжлэлд хамруулсан.
- “Топ шайн” ХХК-ийн агуулах итгэмжлүүлэх хүсэлтийн дагуу агуулахын үйл ажиллагаатай танилцан, итгэмжлэлийн баримт бичиг бүрдүүлэхэд зөвлөгөө

өгч ажиллан итгэмжлэлд хамруулж, биржийн бараа кодлолын сургалт зохион байгууллаа.

- Дархан-Уул аймагт байрлах “Батбуудай” ХХК, “Монрос рапс” ХХК-тай “Агуулахын итгэмжлэлийн гэрээ” байгуулсан.
- Төв аймгийн “Энх дайжин хангай” хоршооны ирүүлсэн бичиг баримтад хяналт хийж, агуулах итгэмжлэл болон гишүүнчлэлийн гэрээг байгуулсан.

2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Япон Улсын “Озава тент” ХХК Монгол Улсын нөхцөлд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг хадгалах тентен хийц бүхий түүхий эдийн агуулахыг туршин, нэвтрүүлэх зорилгоор “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-тай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгууллаа. Тус хамтын ажиллагааны хүрээнд Япон Улсын тентен хийц бүхий түүхий эдийн туршилтын агуулахыг “Ложистикийн төв”-ийн хашаанд барих, тус туршилтын агуулахаар Монгол орны цаг уур, байгаль орчны нөхцөл, улирлын чанартай бэлтгэгдэж буй түүхий эдийн хадгалалтын горим шаардлагад нийцэх зохицлыг тодорхойлох, түүхий эдийн агуулах барих шинэ материалыг нэвтрүүлэх судалгаа, арга замыг тодорхойлох ач холбогдолтой байх юм.

Олон улсын стандартчиллын байгууллагын “ISO,TC 38/VVG 33” ажлын хэсгийн БО 22786 “Текстил. Мал, амьтны тавлаг байдал, Ноолуур бэлтгэх, шошголох, үйлдвэрлэх, мөшгөх тогтолцоонд тавих шаардлага” стандартыг хэлэлцэх олон улсын экспертүүдийг Монгол орны бэлчээрийн мал аж ахуй, Монголын уламжлалт мал маллах арга, малчин өрхийн аж амьдрал, Эрчмийн хар ямаа болон Монгол орны нөхцөлд ямааны ноолуур хэрхэн бэлтгэдэг талаар таниулах зорилгоор 2024 оны 7 дугаар сарын 13-16-ны өдрийг дуустал хугацаанд Хөвсгөл аймагт ажилласан. Энэхүү ажлын үр дүнд “Текстил. Мал, амьтны тавлаг байдал, Ноолуур бэлтгэх, шошголох, үйлдвэрлэх, мөшгөх тогтолцоонд тавих шаардлага” олон улсын стандартыг санаачлагч тал зөвхөн байран маллагааны шаардлагуудыг багтаасан нь учир дутагдалтай, бэлчээрийн мал аж ахуйг орхигдуулсанаа хүлээн зөвшөөрсөн бөгөөд дараагийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн төсөлдөө тусгахаар тогтсон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК, Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоотой хамтран Хэнтий аймгийн салбар хариуцсан мэргэжилтнүүд, хоршоодыг “Арьс ширэн түүхий эд бэлтгэлийн цахим сургалт”-д хамруулж мэдээллээр хангах, чадваржуулах, цаашид зорилтот хэрэглэгчид болох малчин, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгчид, хоршоодыг чадавхжуулах, давтан сургах замаар түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг сайжруулах зорилго бүхий сургалтыг Хэнтий аймгийн Хэрлэн суманд 2024 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 73 түүхий эд бэлтгэн нийлүүлэгч хоршоодын гишүүд хамрагдсан.

4.2. Гишүүнчлэл, байнгын болон байнгын бус гишүүн:

Байнгын гишүүн:

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/ болох “Хаан Тэлмэн” ХХК, “Ханбүргэд Хэнтий” ХХК, “Алтаншагай импекс” ХХК “Бадархундага Оргил” ХХК, “Роял кашимер” ХХК “Цэц-Инвест” ХХК-иуд биржтэй “Гишүүнчлэлийн гэрээ”-г сунгаж, биржийн арилжаанд

идэвхтэй оролцож байна. "Суварга Алтай констракшн" ХХК нь "Гишүүнчлэлийн гэрээ" сунгаагүй тул арилжаанд оролцохгүй байна.

Байнгын бус гишүүн:

"Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо"-ны гишүүн хоршоодыг чадавхжуулж, биржийн арилжаанд оролцуулах, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК, "Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо"-той хамтран ажиллаж "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд үүсгэн байгуулагдсан хоршооны мэдээлэл авч ажиллаж байна.

Хэнтий аймгийн 6 сумын 8 хоршоо биржтэй "Гишүүнчлэлийн гэрээ" байгуулж, биржийн талаар мэдээлэл авсан ба ингэснээр биржийн байнгын бус гишүүний тоо 94 болж өссөн.

Байнгын бус гишүүний гэрээний хугацаа 1 жил байгаатай холбогдуулан орон нутгийн агуулахын тоо буурах, жил тутам гэрээ шинэчлэн байгуулах нь хоршоодод хүндрэл, төвөгтэй байдал, санхүүгийн үр ашиггүй зардал гаргах зэрэг нөхцөлийг бий болгож байсан тул 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/84 тушаалаар Гишүүнчлэлийн журамд өөрчлөлт оруулан батлуулсан. Үүнд:

1. "Гишүүнчлэлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.21.3-т "Үйл ажиллагаа явуулж буй тухайн сумын малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлэх боломжтой байх" гэснийг "Үйл ажиллагаа явуулж буй хоршоо нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг байх;" гэж, тус тушаалын хавсралтаар баталсан. "Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх материалын жагсаалт"-ын 2 дахь шалгуур үзүүлэлтэд заасан "Үйл ажиллагаа явуулж буй тухайн сумын малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлэх боломжтой байх" гэснийг "Үйл ажиллагаа явуулж буй хоршоо нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг байх;" гэж тус тус өөрчлөлт оруулсан.
2. Журмын 3 дугаар зүйлийн 3.21.12-т "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд үүсэн байгуулагдсан хоршоо нь энэ журмын 3.21.10, 3.21.11 дахь заалтад хамаарахгүй болно", 3.21.13-т "Дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан байнгын бус гишүүнтэй байгуулах "Гишүүнчлэлийн гэрээ"-г 3 жилийн хугацаатай байгуулна" гэж оруулсан.

ТАВ. ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ

5.1. Арилжаа, төлбөр тооцооны систем

Тайлант хугацаанд 178 удаагийн цахим арилжаагаар 936 хэлцлийг зохион байгуулсан байна.


Дуудлага худалдааны системээр мал, махны болон хүнсний улаанбуудай, үрийн улаанбуудай, тэжээлийн улаанбуудай, “Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл”-ийн дуудлага худалдаа зэрэг нийт 668 арилжааг зохион байгуулж системийн найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байна.

Энэ хугацаанд нийт 22 удаагийн техникийн асуудал үүссэнийг цаг тухай бүрд алдааг хянан засварлаж, байгууллагын үйл ажиллагааны болон бизнесийн эрсдэл, доголдол үүсгэлгүй ажилласан.


“Айтүүлс” ХК-тай “Блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн ашиглалтад дэмжлэг үйлчилгээ үзүүлэх” гэрээг байгуулсан бөгөөд тус системд Хаан банкны CGW үйлчилгээг ашиглаж автоматаар дэнчингийн данснаас дэнчинг татаж орлого хийх, арилжааны дараа дэнчингийн буцаалтыг автоматаар хийх хөгжүүлэлтийн ажлууд хийгдсэн.

5.2. Экспортын нэг цонхны систем

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн “Экспортын нэг цонхны систем”-ээр тайлант хугацаанд 1170 экспортын хүсэлт бүрэн шийдвэрлэгдэж, 144,244.05 тонн махны экспортын зөвшөөрлийг гаргасан байна. Мөн системд импортын мэдэгдэлийн 4 төрөл, дамжуулан өнгөрүүлэх 2 төрлийн үйлчилгээг нэвтрүүлэн ашиглаж байна.



Бүрэн шийдвэрлэсэн хүсэлтийн тоо



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛ /ГЕГ/

/2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

№	Махны нэр төрөл	Экспортлолсон улс	Экспортлолсон тоо хэмжээ, кг	Мөнгөн дүн, ам.дол	ААН тоо	Хил нэвтэрсэн боомт
1	Адууны мах	ОХУ	75,250	242,039	15	Замын-Үүд, Алтанбулаг, Чингисхаан ОУНБ
		Япон	600	4,618		
		БНХАУ	22,413,000	79,444,199		
		Узбекистан	301,400	1,009,260		
		Казахстан	1,060,000	3,538,449		
		Нийт	23,850,250	84,238,565		
2	Хонь, ямааны түүхий мах	Азербайжан	534,667	1,806,043	29	Алтанбулаг, Цагааннуур, Чингисхаан ОУНБ
		Иран	17,184,399	66,080,653		
		Ирак	3,328,943	13,344,254		
		Хонконг	1,259,720	3,953,726		
		Узбекистан	1,179,880	3,932,651		
		Арабын нэгдсэн эмират	1,250	3,625		
		Катар	81,760	280,207		
		Вьетнам	20,060	86,108		
		Армен	20,000	68,100		
		Тажикстан	35,500	131,750		
		Кувейт	6,978	28,781		
		Нийт	23,653,157	89,715,898		
3	Үхрийн түүхий мах	Узбекстан, ОХУ	189,500	653,978	3	Алтанбулаг
4	Малын дайвар	Хонконг, Вьетнам, Узбекистан, Ирак	696,432	799,274	4	Алтанбулаг, Чингисхаан ОУНБ
5	Өлөн	Австри, Импани, Хонконг, Казахстан, Япон, Итали, Дани,	776,062	13,318,188	5	Сүхбаатар, Чингисхаан ОУНБ

6	Дулааны аргаар боловсруулсан мах	БНХАУ	20,750,140	93,093,475	13	Замын-Үүд
	Үхрийн мах		4,268,880	21,015,734		
	Хонь, ямааны мах		16,481,260	72,077,741		
	Консерв	ОХУ /үхрийн, ямааны/	74,199	247,912	4	Алтанбулаг, Чингисхаан ОУНБ
		БНСУ /үхрийн, ямааны/	76,694	212,952	3	
		Нийт	150,892	460,864		
НИЙТ МАХНЫ ЭКСПОРТ			71,150,033 кг			

5.3. Биржийн мал, махны зарын систем

Биржийн мал, махны зарын платформыг хөгжүүлэн 2024 оны 1 дүгээр сараас ашиглаж эхлээд байна. Мал, махны зарын <https://trade.mce.mn/> платформын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, нэмэлт сайжруулалтыг хийж гүйцэтгүүлэн одоогийн байдлаар 223 зар нийтлэгдэн арилжаанд ороод байна. Хөдөө аж ахуйн биржийн мал, махны зарын платформыг монгол үг ашиглан www.ariljaa.mce.mn домейн нэрийг өөрчлөн үүсгэж, мал, махны зарын платформ холболтыг хийсэн. Интернет орчны оновчтой хайлтын систем буюу SEO систем дээр ашиглагдах шаарлагатай түлхүүр үг, мал, мах, худалдаа, зар, зарах, авах гэх мэт мэдээллийг бэлтгэв.

5.4. Багцын гэрээний систем

Биржийн байнгын бус гишүүн хоршоо, үйлдвэр хоорондын арилжаанд “Багцын гэрээний систем”-ийн ашиглалт хөгжүүлэлтийн гэрээ”-г “Майндсимбол” ХХК-тай байгуулсан. Систем хөгжүүлэлтийн ажлыг 2023 онд хийж эхэлсэн ба 2024 оноос биржийн арилжаанд орсон хэлцлийн мэдээнд үндэслэн худалдагч, худалдан авагч талын татвар төлөгчийн дугаарыг бүртгэж, и-баримт үүсгэдэг болсон. Татварын и-баримтыг биржийн арилжаанд орсон экспортод гаргах тосны ургамлын нэр төрөл дээр амжилттай үүсгэж эхлээд байна.

5.5. Компанийн веб хуудас

Компанийн веб хуудас www.mce.mn домэйнээр ажиллаж, нэмэлт хөгжүүлэлт, шинэчлэлийг хийж ажиллав. Нийтийн ил тод мэдээллийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагатай мэдээллүүдийг байршуулах, байгууллагын үйл ажиллагааг гадаад улсад сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, ажлын хүрээнд байгууллагын албан ёсны веб хуудасны англи хэлний хувилбар бий болгох, тэргүүлэх хайлтын системийн эхэнд гарч ирэх, ноолуур болон махны үнийн мэдээллийг 252BI tool ашиглан веб хуудсанд байршуулж харуулдаг болсон.

ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ

Компанийн батлагдсан “Стратеги төлөвлөгөө 2022-2026”-нд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөр компанийн “Бизнес төлөвлөгөө 2024”-г батлуулан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэлээ.

6.1. Төрөөс хөдөө аж ахуй салбарт хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилт:

Монгол Улсын Их Хурлаар баталсан тогтоолын хэрэгжилтийн талаар:

➤ Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд “Мах бэлтгэхэд зориулан олгох хөнгөлөлттэй зээл”-ийг 2024 онд үргэлжлүүлэн олгож, санхүүжилтийг арилжааны банкны эх үүсвэрээр, Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцож, мах худалдан авсан хоршоо, аж ахуй нэгжид олгохоор шийдвэрлэсний дагуу “Мах бэлтгэхэд зориулан олгох хөнгөлөлттэй зээл” олгох зохицуулалт, үйл ажиллагааны зураглал, арилжааны схемийг гарган танилцуулга бэлтгэж, зураглалын дагуу арга хэмжээ авч ажиллалаа.

“Мах бэлтгэхэд зориулан олгох хөнгөлөлттэй зээл”-ийг 2024 онд үргэлжлүүлэн олгож, санхүүжилтийг арилжааны банкны эх үүсвэрээр эхний ээлжинд Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцож, мах худалдан авсан этгээдэд олгохоор шийдвэрлэсний дагуу хөнгөлөлттэй зээлд хамрагдах нийт 136 хүсэлт ирүүлснээс аж ахуйн нэгжийн 58, хоршооны 9, иргэний 70 хүсэлтийг тус тус хянаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 9 удаагийн албан бичгээр хүргүүлсэн ба хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжээс биржийн арилжаанд оролцохоор ирүүлсэн хүсэлтийн дагуу арилжааг цаг тухай бүр зохион байгуулсан. “Мах бэлтгэхэд зориулан олгох зээл”-ийн талаар авах арга хэмжээтэй холбоотой мэдээ мэдээллийг (+976) 7013-8779 утсаар хүлээн авч, хариу өгч ажиллаж байна.

➤ Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 31 дүгээр тогтоолын хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/42 дугаар тушаалаар “Улсын нөөцөд худалдан авах болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлэх хүнсний улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжих бэлтгэл ажлыг хангах, арилжааг зохион байгуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан ба гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу ажилласан.

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/98 дугаар тушаалаар “Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны түр журам”-ыг баталж, улмаар 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Дархан-Уул аймагт “Улаанбуудайн дуудлага худалдаа”-г цахим болон танхимаар анх удаа зохион байгууллаа. Тус арилжаагаар “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн өр авлагад хураан авсан нийт 528 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2024 оны хураалтын 20 тн хүнсний улаанбуудай, 2023 оны хураалтын 530 тн тэжээлийн улаанбуудай, 2024 оны хураалтын 228 тн тэжээлийн улаанбуудайг тус тус арилжсан.

Мөн “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК хамтран корпорацийн үр тарианы агуулахад хадгалагдаж буй 2025 оны тариалалтад

ашиглагдах үрийн улаанбуудайг биржээр анх удаа арилжаалж эхэлсэн бөгөөд 7 сортын 1.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нийт 962 тонн үрийн улаанбуудайн арилжааг амжилттай зохион байгуулаад байна.

➤ Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хүрээнд “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг боловсруулан, Улсын Их хурлын байнгын хорооны 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 25 зүйлтэйгээр боловсруулсан. “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо”-г Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гүйцэтгэсэн ба тус хуулийн төслийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу Хуулийн хэлтэст шилжүүлсэн. Биржийн зүгээс хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулахтай холбоотой үйл ажиллагаанд бүхий л талаас дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

Мөн малын гаралтай түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгож, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2024 оны А/80 дугаар тушаалаар “Амьд малын төвлөрсөн цэгийг боломжит бүсэд байгуулах судалгаа хийх, бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагуудын талаарх судалгаа;
- Амьд мал болон мах худалдаалах зах зээлийн суурь судалгаа;
- Малын төвлөрсөн цэг байгуулах боломжит бүс, байршлын талаархи судалгаа;
- Мал, махны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагыг төрөөс дэмжиж буй урамшуулал, дэмжлэгийн талаарх судалгаа;
- Малын тэжээлийн норм норматив, махны стандарт, үйл ажиллагаанд мөрдөж буй стандартуудын талаарх судалгаа зэрэг судалгааны ажлуудыг тус тус хийн нэгтгэсэн.
- 10 га газар амьд малын захын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг, төсвийн үнийн саналыг “зураг төслийн ажлын жишиг үнэ” БД 81-16-20-ийн дагуу тооцож боловсруулан аж ахуйн нэгжүүдээс холбогдох саналыг авсан.
- Хэнтий аймгийн Баян-Овоо суманд "Баялаг гүрэм" загвар хоршоог байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооноос баталсан тогтоолын хэрэгжилтийн талаар:

➤ Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны “Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь мах, махан бүтээгдэхүүний экспортын худалдааг хөнгөвчлөх, экспортын гэрчилгээ олгох үйл явцыг хурдан шуурхай гүйцэтгэх зорилгоор “Экспортын нэг цонхны систем”-ийг хөгжүүлэн нэвтрүүлсэн. Тус системд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, Стандарт

хэмжил зүйн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд холбогдсон ба экспортын гэрчилгээ авах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллага өмнө нь 13-15 өдөр зарцуулдаг байсаныг хөнгөвчилж 2 өдөрт багтаан шийдвэрлэдэг болсон.

Экспортын нэг цонхны системээр 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 сарын байдлаар мах, махан бүтээгдэхүүний экспортлогч 163 компани бүртгэл хийлгэж, 1129 экспортын хүсэлтээр 142,815.66 тонн мах экспортолсон байна. Энэхүү системээр ноос ноолуур, арьс шир, тосны ургамал зэрэг хөдөө аж ахуйн гаралтай 27 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтийг гүйцэтгэхээр систем хөгжүүлэлтийг хийж бэлэн болгосон ба тус системээр мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ олгох үйл ажиллагаа тогтмол хийгдэж хэвшсэн байна.

Монгол Улсын Засгийн Газраас баталсан тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийн талаар:

➤ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 233 дугаар тогтоолын биелэлтийг хангах ажлын хүрээнд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдаалах, дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд шууд хүргэхээр дараах боломж нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд:

- “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулиар “Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, түүнийг коджуулах журам”-ыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах эрхтэй байдаг бөгөөд өнөөдрийн байдлаар биржийн барааны жагсаалтад ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, амьд мал, арьс, шир, мах, хүнсний улаанбуудай, тосны ургамал, малын тэжээл, үрийн улаанбуудай зэрэг 8 бүлгийн бараа, түүхий эд бүртгэгдээд байна.

Биржээр дамжуулан мал, махны арилжааг зохион байгуулах үйл ажиллагааг 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд албан ёсоор эхлүүлсэн. 2024 оны 12 дугаар сарын байдлаар 542 хэлцлээр 15.8 тэрбум төгрөгийн арилжааг зохион байгуулаад байна.

Тус тогтоолын Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн биржийн арилжааны 90 гаруй хувийг ямааны ноолуурын арилжаа эзэлдэг ба биржээр арилжих бараа, түүхий эдийн арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээ угаасан ноолуур 0.8 хувь, самнасан ноолуур 0 хувь, бусад бүх бараа, түүхий эдэд 0.32 хувь байдаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Санхүүгийн зохицуулах хорооноос дараах тогтоолуудыг баталсан. Үүнд:

- 2022 онд “Биржийн байнгын бус гишүүн хоршоо, тэдгээрийн бэлтгэсэн бараа түүхий эдийг худалдан авч буй үйлдвэр хоорондын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 3 жилийн хугацаанд 0 хувь болгон тогтоосон.
- 2024 оны 06 дугаар тогтоолоор мал, махны арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 0 хувь болгон тогтоосон.

- 2024 оны 13 дугаар тогтоолоор самнасан ноолуурын арилжаа, төлбөр тооцооны хувь хэмжээг 0.62 хувь байхаар шинэчлэн тогтоосныг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 211 дүгээр тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын 3 дахь заалтыг “2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөн баталсантай холбогдуулан тогтоолын хэрэгжилтийн хугацааг мөн хугацаагаар хойшлуулсан.
- Мөн “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын 3 дахь заалтыг “2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөн баталсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Хөдөө аж ахуйн биржээс Санхүүгийн зохицуулах хороонд тавьсан саналын дагуу Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн нийт арилжааны дүнгээс суутган тооцох Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс нь 0.04 хувиас доошгүй байсныг Хорооны даргын 2024 оны 491 дүгээр тогтоолоор 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд угаасан ноолуур 0.02 хувь, самнасан ноолуур 0 хувь, үрийн болон хүнсний улаанбуудай 0 хувь байхаар тус тус тогтоосон.

➤ “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зүйл заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолын биелэлтийг хангах ажлын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр Монгол Улсын Засгийн газраас зээлийн хүүгийн татаас олгон хоршоодод жилийн 6 хувийн хүүтэй 3-5 жилийн хугацаатай төслийн хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн бөгөөд 5 жилийн хугацаанд 5 их наяд төгрөгийн зээлийг төлөвлөгөөний дагуу олгож эхэлсэн. Тус хөдөлгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- “Загвар хоршоо”-ны Техник, эдийн засгийн үндэслэлийн хөрөнгө оруулалтын тооцооллыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрлэлийн газартай хамтран бэлтгэсэн.
- Малчдын хоршоодод танилцуулж, хэрэгжүүлэх зорилгоор мал, мах, сүү бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах, түүхий эд бэлтгэлийн агуулах барих төслүүдийг тус тус боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.
- Малчид, хоршоодод зориулсан гарын авлагын эх бэлтгэлд “Хоршоо биржийн арилжаанд хэрхэн оролцох тухай” мэдээлэл, зааварчилгааг бэлтгэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
- Хөдөө аж ахуйн биржээс Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Архангай, Завхан, Говь-Алтай, Дорнод аймгуудад сургагч багш томилон ажилласан.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ний өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоолын биелэлтийг хангах ажлын хүрээнд малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр худалдан борлуулах, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн үнийг хязгаарлах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байх зорилгоор малчдаас дундын зуучлалгүйгээр эцсийн хэрэглэгчдэд шууд хүргэх боломжийг бүрдүүлэн бирж нь дараах ажлуудыг гүйцэтгэн ажилласан. Үүнд:

- Экспортын нэг цонхны системийг бүрэн нэвтрүүлсэн.
- Мал, малын гаралтай бүтээгдэхүүний хялбар худалдааны платформыг хөгжүүлэн нэвтрүүлсэн.
- Малын төвлөрсөн захыг эрчимжсэн мал аж ахуй төвлөрсөн бүс нутагт байгуулах судалгааг хийж, төслийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан.
- Мал, махны биржийн арилжааг тодорхой чиглэлүүдээр зохион байгуулах зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Эмээлтэд байрлах биржийн “Ложистикийн төв”-д “Малын төвлөрсөн арилжаа” -г тогтмол зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, арилжаа зохион байгуулахад бэлэн болсон боловч “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг түүний харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхээр тусгаж, Засгийн газрын хуралдааны 32 дугаар тэмдэглэлээр холбогдох албан тушаалтанд үүрэг даалгавар өгсөнтэй холбогдуулан цаг үеийн асуудлаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Малын төвлөрсөн арилжааны зорилго нь орон нутгийн малчид, хоршоодоос Улаанбаатар хотын мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт дундын зуучлалгүйгээр амьд мал нийлүүлэх ложистикийн сүлжээг бий болгох, эрүүл мэндийн шаардлага хангасан малыг зах зээлд нийлүүлэх, эрэлт, нийлүүлэлт, чанарт суурилсан зах зээлийн бодит үнийг тогтоох, улмаар түүхий эдийн үнэ цэнийг өсгөж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр “Мал, махыг биржээр худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх, Монголын хөрөнгийн биржийн платформоор дамжуулан арилжаалах арга хэмжээг 2024 оны 1 дүгээр сард багтаан зохион байгуулж ажиллах тухай” шийдвэр гарсаны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэгээр ахлуулсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Хөдөө аж ахуйн бирж, Монголын хөрөнгийн биржийн хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан ба тус ажлын хэсэгт танилцуулагдах “Хөдөө аж ахуйн биржээр амьд мал, мах арилжиж буй ажлын танилцуулга”-ыг боловсруулж ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 50 дугаар тэмдэглэлээр даалгасан ажлын үр дүнг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны хуралдааны 5 дугаар тэмдэглэлээр “Хөдөө аж ахуйн биржээр дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд нийлүүлэх амьд мал, махны арилжааг зохион байгуулах, “Мах бэлтгэхэд зориулан олгох хөнгөлөлттэй зээл”-ийг 2024 онд үргэлжлүүлэн олгож, 12 хүртэл сарын хугацаатай, жилийн 6 хүртэл хувийн хүүгийн нөхцөлтэйгээр хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны санхүүжилтийн эх үүсвэрээр олгох”-оор шийдвэрлэсэн бөгөөд тус тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн биржийн дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформ болон мал, махны захиалгын зарын www.ariljaa.mce.mn платформыг хөгжүүлэн эдгээр платформуудаар дамжуулан малчдын бэлтгэсэн мах болон амьд малын худалдааг дундын зуучлалгүй

худалдан авах, хэрэглэгчдэд нийлүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвшсэн.

Компанийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ:

➤ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 31 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.4-т заасны дагуу Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-д амьд мал, мах болон хүнсний улаанбуудайн нэр төрлөөр тусгай зөвшөөрлийн эрхийг олгох тухай асуудлаар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газартай албан уулзалт хийсэн бөгөөд уулзалтаар Монгол Улсын Их Хурлын 2022 онд баталсан “Зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий арилжааны зуучлагч /брокер/-д бараа, түүхий эдийн нэр төрөл тус бүрээр тусгайлан тусгай зөвшөөрлийн эрх олгохгүй бөгөөд арилжааны зуучлагч /брокер/ нь Хөдөө аж ахуйн биржээр арилжих барааны жагсаалтад багтсан бараа, түүхий эд бүрээр арилжааны зуучлалын үйлчилгээ үзүүлэх эрхтэй болохыг мэдэгдсэн.

➤ “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн 4.5, 4.6 дахь хэсгийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/668 дугаар тушаалаар биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад Малын тэжээл болон Үрийн улаанбуудайг нэмж баталсан.

➤ Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах арга хэмжээний тухай 218 дугаар тогтоолоор Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах, төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдах бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон.

Үүний хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Компанийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан мэдээнд үндэслэн Бизнесийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ, Хууль зүйн дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээ, Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөх үйлчилгээ, Андеррайтерийн компанийн зөвлөх үйлчилгээнүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шалгаруулан гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд эдгээр байгууллагуудад компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг гарган өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэгч андеррайтерийн компанид “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн 2025-2030 оны “Бизнес төлөвлөгөө”-г бэлтгэж хүргүүлсэн. Хөдөө аж ахуйн биржийн Хувьцааны үнэт цаасны танилцуулгын төслийг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Андеррайтерын компаниас хүлээн авч, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад хүргүүлсэн болно.

6.2. Судалгаа, мэдээлэл:

2024 онд биржээр мал махны арилжаанд www.cloud.mce.mn системээр бүртгэгдсэн оролцогчдын хэлцлийн мэдээ мэдээллийн судалгааг гаргасан.

www.ariljaa.mce.mn худалдааны зарын платформд Өвөрхангай, Булган, Дорнод, Говь-Алтай, Архангай, Ховд, Сүхбаатар, Өмнөговь, Хэнтий аймгуудаас махны худалдах хүсэлт, захиалгуудыг аймаг, сумдын удирдлага, Хүнс, Хөдөө аж ахуйн газартай холбогдон байршуулсан ба нийт зарын нэгтгэл судалгааг гаргасан.

Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүний “Экспортыг нэг цонх”-ны бодлогоор хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хөдөө аж ахуйн бирж нь экспортын махны жишиг үнийг гулууз мах, цул мах, экспортын хөлдөөсөн мах болон экспортын дулааны аргаар боловсруулсан мах гэсэн нэр төрөл тус бүрээр “Өртөг, зардлаас тооцох арга”-аар тооцоолон гаргасан. Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийг гадаад зах зээлд бууруулахгүй байх үүднээс экспортын барааны гаалийн үнийг тогтоохдоо энэхүү жишиг үнээс багаар тогтоохгүй байх чиглэлийг барьж, хамтран ажиллах тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан бичгийн төслийг боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.

“Орон нутагт мал төхөөрөх явуулын машин үйлдвэрлэл” сэдэвт төсөл боловсруулж танилцуулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн жагсаалтыг гарган төслийн нэр, төслийн зохицуулагч, санхүүжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэгч байгууллага, төслийн санхүүжилтийн хэмжээ /ам.доллар/, үлдэгдэл санхүүжилт, төслийн хэрэгжих хугацаа зэрэг мэдээллийг гарган танилцуулсан.

Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааны ноолуурын экспорт хийж буй аж ахуйн нэгжүүдийн ноолуурын ангилал, төрөл, тоо хэмжээ, үнийн дүн, гаргасан боомтын нэр, зөвөрлөж буй хэлбэр, экспортолж буй улсын нэр, биржээр арилжсан барааны тодорхойлолттой эсэх зэрэг мэдээллийг ангилан гаргаж, түүн дээр боловсруулалт, дүгнэлт хийсэн .

Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд экспортлогдсон ноолуурын экспортын гаалийн мэдээлэл болон биржээр дамжуулан арилжаанд орсон аж ахуйн нэгжийн мэдээллийг харьцуулан, биржийн арилжаанд ороогүй аж ахуйн нэгжийн нэр, ноолуурын тоо хэмжээ, төрлийг гарган танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу хувьцаа эзэмшигч болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн 2025-2030 оны “Бизнес төлөвлөгөө”-г боловсруулахад компанийн 2030 он хүртэлх хугацааны ашгийн тооцоололын таамаглалыг гаргав.

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн 4.5, 4.6 дахь хэсгийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/668 дугаар тушаалаар биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад Малын тэжээл болон Үрийн улаанбуудайг нэмж баталсантай холбогдуулан Багсармал тэжээл, Ногоон тэжээл, Өвс, Хивэгний ерөнхий шинж, зах зээлийн судалгааг тус тус гаргасан.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 178 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 936 хэлцлээр 996.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 5,862.5 тонн ямааны ноолуур, 3,400.6 тонн ямааны завод ноос, 6,392.0 тонн хонины ноос, 1,020.6 тонн тэмээний ноос, 26.5 тонн завод ноос, 1,100.0 тн хүнсний улаанбуудай, 4,422.0 тонн тосны ургамал /рапс/ арилжсан.

Монгол Улсын Засгийн газрын 233 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2023 оны 50 дугаар тэмдэглэл болон 2024 оны 5 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэн өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн, зудад өртөх магадлал бүхий аймгуудын малчдын гар дээрх мал, махыг зах зээлд нийлүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор төлөвлөгөө гарган түргэн шуурхай ажиллалаа. Үүний дүнд нийт 20.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1,892.3 тн мах, 34,744 толгой амьд хонины арилжааг зохион байгуулсан. Үүнд, 602.7 тн хонины мах, 664.5 тн үхрийн мах, 393 тн ямааны мах, 201.1 тн адууны мах, 31.0 тн тэмээний мах худалдан борлуулж 399 малчин иргэн, 22 аж ахуй нэгж оролцлоо. Мал, махны арилжаанд оролцсон 21 иргэн, аж ахуйн нэгжид тодорхойлолт олголоо.


2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 2024 оны ургац хураалтын 20 тонн хүнсний улаанбуудай, 2023 оны ургац хураалтын 530 тонн тэжээлийн улаанбуудай, 2024 оны ургац хураалтын 228 тонн тэжээлийн 528 сая төгрөгийн үнийн дүн бүхий улаанбуудайг дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжсан.

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 26-ны өдрийн хугацаанд дээрх 7 сортын 1066 тонн үрийн улаанбуудайг арилжсан ба дуудлага худалдааны арилжааны үнийн дүн 1.7 тэрбум төгрөг байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйлдвэрийн дэргэдэх 25 агуулах, орон нутгийн 116 агуулах биржтэй “Агуулахын итгэмжлэлийн гэрээ” байгуулж, хамтран ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/ болох “Хаан Тэлмэн” ХХК, “Ханбүргэд Хэнтий” ХХК, “Алтаншагай импекс” ХХК “Бадархундага Оргил” ХХК, “Роял кашимер” ХХК “Цэц-Инвест” ХХК-иуд биржтэй “Гишүүнчлэлийн гэрээ”-г сунгаж, биржийн арилжаанд идэвхтэй оролцож байна. “Суварга Алтай констракшн” ХХК нь “Гишүүнчлэлийн гэрээ” сунгаагүй тул арилжаанд оролцоогүй. Биржийн байнгын бус гишүүний тоо 94 болж өссөн.

Экспортын нэг цонхны системээр 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийн байдлаар мах, махан бүтээгдэхүүний экспортлогч 166 компани бүртгэл хийлгэж, 1170 экспортын хүсэлтээр 144,244.05 тонн мах экспортолсон байна. Энэхүү системээр ноос ноолуур, арьс шир, тосны ургамал зэрэг хөдөө аж ахуйн гаралтай 27 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтийг гүйцэтгэхээр систем хөгжүүлэлтийг хийж бэлэн болгосон ба тус системээр мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ олгох үйл ажиллагаа тогтмол хийгдэж хэвшсэн байна.



Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд орсон хэлцлийн мэдээнд үндэслэн худалдагч, худалдан авагч талын татвар төлөгчийн дугаарыг бүртгэж, и-баримт үүсгэдэг болсон. Татварын и-баримтыг биржийн арилжаанд орсон экспортод гаргах тосны ургамлын нэр төрөл дээр амжилттай үүсгэж эхлээд байна.

2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 1.5 сая болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 909 хувиар өссөн байна. Мөн цахим хуудасны дагагчдын тоо 2600 гаруй хүнээр нэмэгдсэн нь мөн үетэй харьцуулбал 154 хувиар өссөн. Энэхүү үзүүлэлт нь цэвэр органик өсөлт бөгөөд нэмэлт төлбөртэй мэдээ байршуулалгүйгээр нэмж чадсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу хувьцаа эзэмшигч болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн 2025-2030 оны “Бизнес төлөвлөгөө”-г боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 26 дугаар тогтоолын хавсралтаар батлуулсан.

~o0o~